

ДОТООД АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хууль зүйн яам, түүний харьяа агентлаг, байгууллагын дотоод аудитын журам”, байгууллагын Дотоод аудитын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01-09/03 дугаар удирдамжийг үндэслэн Төв болон боомт, орон нутаг дахь нэгжүүдийн 2024 оны нэгдүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын хяналт шалгалтын дагуу дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Шилэн дансны цахим www.shilendans.gov.mn хуудсанд мэдээллийг үнэн зөв, бодитой, иж бүрэн тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлж, цаашид хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд байршуулах, байршуулж буй мэдээллийн чанар, агуулга, үнэн зөв, иж бүрэн байдалд анхаарал хандуулж ажиллах;

3. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, тушаалыг үнэн зөв, бүрэн мэдээлэх;

4. Удирдлагаас хүргүүлсэн үүрэг чиглэл, албан даалгавар, дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

5. Төсвийн шууд захирагчаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах;

6. Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн төсвийн байгууллагын албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор jargalmaa.l@immigration.gov.mn хаягаар ирүүлж, үр дүнг тайлагнаж ажиллана уу.